

## Дэлхийн Мацаг барих ба Залбирлын Өдөр 2021 оны 1-р сарын 13

**Магтаал**—Бурхан бол Ялгуусан! Бүрэн эзэмдэн эзлэн авч, ялан дийлж, давж гардаг Нэгэн.

**Библийн эшлэл:** 1 Шастир 29:11, Дуулал 44:3-7, 1 Коринт 15: 54-57

**Гэмшил**—1 Иохан 5:3-5

**Талархал**—Дуулал 118:15-17

**Зуучлан залбирах**—Дуулал 45:4



**Итгэгчид:** \_\_\_ ямагт Христийг дагаж, ялалтын жагсаалд хөтлөн алхуулдаг Бурханд талархаж, Түүний талаарх мэдлэгийн анхилуун үнэрийг хаа саагүй түгээх болтугай. **2 Коринт 2:14**

*Итгэгч бүх хүүхдүүд, багш, удирдлага захиргааны ажилчид болон сургуульд алба хашиж буй бүх хүмүүс*

*Таньтай үй зайгүй ойр байхдаа бие биеэ хайрлаж*

*Сүнсний үр жимсээр бялхаж*

*Гэрэл ба давс болж, Сайн мэдээг ярихдаа зоригтой байж*

*Таны ивээл, чиглүүлэг, мэргэн ухаан, хангамж болон хамгаалалтыг авах болтугай!*

Бусад...

**Итгэгч бус хүмүүс:** \_\_\_\_ Есүс бол Эзэн хэмээн амаараа тунхаглаж Христийг Эзэн Та түүнийг үхлээс дахин амилуулсан гэдэгт итгэж аврагдах болтугай. Ром 10: 9

**Сургууль:** Амар тайвны Эзэн Бурхан Та \_\_\_\_\_ сургууль/их сургуульд Сатаныг бидний хөл дор бяцлах болтугай! Ром 16:20

Эзэн, ялалт бол Таны гарт! Тиймээс бидний үр хүүхэд, оюутан, багш нар, удирдлагын ажилчид болон сургуулийн бүх албан хаагчдад доорх нөхцөлд ялж дийлэхэд туслаач!

*Айдас хүйдэс, ганцаардал, цөхрөл, найдвар алдах, санаа зовнил, хов жив, амиа хорлох санаархал*

*Уур хилэн, хорсол, үзэн ядалт, шударга бус байдал, өс хонзон, гадуурхал болон хүчирхийлэл*

*Өвчин, донтолт, доромжлол, өөрийгөө гэмтээх, үл ойшоосон байдал*

*Буруу зүрүү хөтөлбөр, дайсны хууран мэхлэлт, төөрөгдүүлэл*

Бусад...

\_\_\_\_\_ сургууль дээр дайсанд булаалгасан бүх газар нутгийг бид Есүсийн нэр дээр буцаан авч байна!

*Хүүхдүүд, багш оюутнууд, удирдлага, захиргааны ажилчдыг маань*

*Сүнсний сэргэлт, гэм буруугийн ятгалаг, гэмшил, шинэчлэл, дахин сэргэлт,*

*Аврал чөлөөлөлт, эвлэрэл,*

*Үнэн, мэргэн ухаан, хэрсүү ухаан, нэвтэрхий ухаан, чиглүүлэг*

*Урам зориг, хангамж, хамгаалалт, авъяас чадвар, хир чадал ба ойлголтоор ивээж өгөөч!*

Бусад...

**Ээжүүд хамтдаа залбирах нь:** Бидний залбирлуудад хариултын хур бороо буулгаж Хаанчлалаа тэлэн Өөртөө Та алдар магтаалын дээжийг хүртэх болтугай! Ээжүүд хамтдаа залбирах нь бүлгүүдийн тоог нэмж залбиралд нь дэлхийн өнцөг булан бүрт байгаа сургууль бүрийг хучаарай Эзэн минь. Хандивлагчдыг бий болгож дэлхий даяар нөөц бололцоо хуримтлагдан түгээгдэх болтугай. Ээжүүд хамтдаа залбирах нь үйлчлэлийг өө сэвгүй байлгаж, энэ нь эв нэгдлийг хадгалах болтугай!

**Адис:** Дуулал 20:5-9